130

**ДУНДГОВЬ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН**
# ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр Дугаар 116 Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх, акталж
данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалт, 6 дугаар бүлгийн 6 дахь хэсгийн 6.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Дундговь-Ус ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 60,342,904 /жаран сая гурван зуун дөчин хоёр мянга есөн зуун дөрөв/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй хөрөнгийг нэгдүгээр хавсралтын дагуу акталж, данснаас хасах, 35,469,608 /гучин таван сая дөрвөн зуун жаран есөн мянга зургаан зуун найм/ төгрөгийн үндсэн хөрөнгийг хоёрдугаар хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгах, 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгийн үндсэн хөрөнгийг гуравдугаар хавсралтын дагуу данс хооронд шилжүүлэхийг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Дундговь-Ус ОНӨҮГ-ын дарга /Д.Ганбаатар/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 сарын 13-ний
өдрийн 116 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## Дундговь-Ус ОНӨҮГ-ын актлуулах хөрөнгийн мэдээлэл

| № | Хөрөнгийн нэр | А/Х | Анхны өртөг | Аш.орсон | тоо/ш | Нийт өртөг | Хур/элэгдэл | Үлдэх өртөг | тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Гүний насосны труба | 30 | 420,000.00 | 1990.01.01 | 28м | 420,000.00 | 420,000.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 2 | Пержим ком | 5 | 166,428.00 | 1995.01.01 | 1 | 166,428.00 | 166,428.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 3 | такорын стинк | 5 | 173,664.00 | 1995.01.01 | 1 | 173,664.00 | 173,664.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 4 | цахилгаан точиль | 3 | 59,697.00 | 1990.01.01 | 1 | 59,697.00 | 59,697.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 5 | Өрмийн стинк | 2 | 54,270.00 | 1990.01.01 | 1 | 54,270.00 | 54,270.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 6 | усны алдагдал хэмжигч багаж | 10 | 898,238.00 | 2005.01.01 | 1 | 898,238.00 | 898,238.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 7 | усны зарцуулалт хэмжигч багаж | 10 | 12,430,158.17 | 2008.01.01 | 1 | 12,430,158.17 | 12,430,158.17 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 8 | чиргүүл | 7 | 559,680.00 | 2006.01.01 | 1 | 559,680.00 | 559,680.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 9 | блокны машин | 5 | 2,385,600.00 | 2011.05.30 | 1 | 2,385,600.00 | 2,385,600.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 10 | гүний насос | 6 | 7,051,906.00 | 2006.01.01 | 2 | 14,103,812.00 | 14,103,812.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 11 | хлор хэмжигч | 5 | 699,600.00 | 2006.01.01 | 1 | 699,600.00 | 699,600.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 12 | эко төхөөрөмж /комьютер/ | 5 | 3,500,000.00 | 2012.03.01 | 1 | 3,500,000.00 | 3,500,000.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 13 | бохирын зөөврийн насос | 5 | 2,704,412.00 | 2008.01.01 | 1 | 2,704,412.00 | 2,704,412.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 14 | бохирын цооног өрөмдөгч /цахилгаан | 5 | 800,000.00 | 2008.01.01 | 1 | 800,000.00 | 800,000.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 15 | HP-85j халаалтын тогоо | 5 | 17,605,500.00 | 2012.11.01 | 1 | 17,605,500.00 | 17,605,500.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 16 | нам даралтын тогоо 0.4 | 5 | 703,000.00 | 2006.01.01 | 1 | 1,406,000.00 | 1,406,000.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 17 | 200.105-н жин | 5 | 38,098.00 | 1993.01.01 | 1 | 38,098.00 | 38,098.000 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 18 | комьпютер | 5 | 874,435.92 | 2004.01.01 | 1 | 874,435.92 | 874,435.92 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 19 | сандал | 5 | 26,080.00 | 2004.01.01 | 1 | 26,080.00 | 26,080.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 20 | хүрэн ширээ | 6 | 488,400.00 | 2007.01.01 | 1 | 488,400.00 | 488,400.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 21 | хурлын ширээ | 6 | 540,450.00 | 2007.01.01 | 1 | 549,450.00 | 549,450.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |

131

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 22 | саарал сейф | 10 | 18,090.00 | 1981.01.01 | 2 | 36,180.00 | 36,180.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 23 | төмөр сейф | 10 | 54,270.00 | 2001.01.01 | 1 | 54,270.00 | 54,270.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 24 | цэнхэр сейф | 10 | 37,989.00 | 1981.01.01 | 2 | 75,978.00 | 75,978.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 25 | ногоон сейф | 10 | 62,953.00 | 1981.01.01 | 1 | 62,953.00 | 62,953.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| 26 | хурлын хүрэн ширээ | 10 | 170,000.00 | 2009.01.01 | 1 | 170,000.00 | 170,000.00 | 0.00 | ашиглагдах боломжгүй болсон |
| | **Нийт дүн** | | | | | **60,342,904 /жаран сая гурван зуун дөчин хоёр мянга есөн зуун дөрөв/** | **60,342,904 /жаран сая гурван зуун дөчин хоёр мянга есөн зуун дөрөв/** | | |

132

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 сарын 13-ний
өдрийн 116 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Дундговь-Ус ОНӨҮГ-ын шинээр бэлтгэх хөрөнгийн мэдээлэл

| № | хөрөнгийн нэр | а/х | орлогодох он сар | хөрөнгөнд бүртгэгдэх үнэ | улсын дугаар | өнгө | тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоног төхөөрөмж | | | | | | |
| 1 | насос -120х | 5 | 2019 | 4,623,500.00 | | | эх үүсврийн 2-р гүний худагт тавьсан |
| 2 | насос 6р 60-1025НР | 5 | 2019 | 4,620,000.00 | | | 5022-н гүний худагт тавьсан |
| 3 | хуванцарын наадаг аппарат Ф250 | 5 | 2019 | 4,698,581.00 | | | ашиглалтанд байгаа хөрөнгөнөөс шилжүүлэх |
| 4 | насос 30квт | 5 | 2019 | 5,048,800.00 | | | уурын зуухны насос /өөрийн хөрөнгөөр/ |
| 5 | хуванцарын наадаг аппарат Ф160 | 5 | 2019 | 3,978,727.00 | | | ашиглалтанд байгаа хөрөнгөнөөс шилжүүлэх |
| | Тоног төхөөрөмжний үнийн дүн | | | 22,969,608.00 | | | |
| | Тээврийн хэрэгсэл | | | | | | |
| 6 | портер-2 /ачааны зориулалттай давхар кабинтай | 10 | 2019 | 12,500,000.00 | 43-53 дуа | цагаан | өөрийн хөрөнгөөр |
| | тээврийн хэрэгслийн дүн | | | 12,500,000.00 | | | |
| | Нийт дүн | | | 35,469,608.00 | | | |
| | | | | 35,469,608 /гучин таван сая дөрвөн зуун жаран есөн мянга зургаан зуун найм/ | | | |

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 сарын 23-ний
өдрийн 116 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн бүртгэлээс тоног төхөөрөмжийн бүртгэл рүү шилжүүлэх

| № | хөрөнгийн нэр | а/х | анхны өртөг | а/орсон он | тоо/ш | нийт өртөг | хур/эл | үлдэх өртөг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | цахилгаан тоолуур 1-р станц | 30 | 50000.00 | 1990.01.01 | 2 | 100,000.00 | 100,000.00 | 0 | |
| 2 | цахилгаан тоолуур 2-р станц | 30 | 50000.00 | 1990.01.01 | 1 | 50,000.00 | 50,000.00 | 0 | |
| 3 | цахилгаан тоолуур 3-р станц | 30 | 50000.00 | 1990.01.01 | 1 | 50,000.00 | 50,000.00 | 0 | |
| | **Нийт дүн** | | | | | **200,000 /хоёр зуун мянга/** | **200,000 /хоёр зуун мянга/** | | |

134

135

# ДУНДГОВЬ АЙМГИЙН
# ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
# ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр                Дугаар 117                Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн хөрөнгөөр бэлтгэсэн 33,000,000 /гучин гурван сая/ төгрөгийн УАЗ-220695-550 маркын суудлын автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Цагаандэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн дарга /А.Өлзийжаргал/-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улирал багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА                С.СҮХБААТАР